



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

**Нэмэгдэл хөлс олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/191 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан халдварт өвчний тархалтаас сэргийлэх хариуцлагатай эргүүл жижүүрт томилогдон ажиллах албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Хариуцлагатай эргүүл жижүүр томилогдон ажиллаж буй албан хаагчдын цаг бүртгэл, тооцоог нарийвчлан гаргаж нэмэгдэл хөлсийг олгохыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т даалгасугай.

3. Нэмэгдэл хөлсийг зохих сангаас олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ